



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 11/27

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/201 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тохиох Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Сувилагчдын бие даасан байдал-Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” сэдэвт аяныг 2022 он 04 дүээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулан явуулсугай.

2. “Сувилагчдын бие даасан байдал- Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” сэдэвт аяны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, аяны ажлын төлөвлөгөөг гуравдугаар, үнэлгээний шалгуур хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяны ажлыг чанартай зохион байгуулан удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Сувилахуйн албаны дарга /Б.Халиунгэрэл/-д даалгасугай.


4. Хийсэн ажлын тайланг аян зохион байгуулах ажлын хэсэгт 2022 оны 05 сарын 9-10-ны өдрүүдэд ирүүлэхийг тасаг нэгжийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. Шилдгээр шалгарсан сувилагч нарын шагнал урамшуулалд зарцуулагдах төсвийг зохих эх үүсвэр болон байгууллагын хандив тусламжаас гаргахыг ахлах нягтлан бодогч /С.Оюун-эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч ЭМТҮЧАБ дарга /Д.Гэжиймаа/-д даалгасугай

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



3 170 7031684

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/27-р тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Д.Гэжиймаа- ЭМТҮЧАБА дарга

Гишүүд:

Б. Халиунгэрэл-Сувилахуйн албаны дарга

Ц.Оюунчимэг –Чанарын менежер

С. Өлзийжаргал-Тархвар судлаач

А. Бүрнээ – Даатгалын эмч

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн
А/27-р тушаалын хоёрдугаар хавсралт

**“ СУВИЛАГЧДЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ – СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛЬЯ”
АЯНЫ УДИРДАМЖ**

Нэг: Үндэслэл:

Монгол улсын их хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2 дахь зорилтод Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ гэж заасан. Үйлчлүүлэгчийн оролцоотой чанартай, аюулгүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэх нь манай улсын төдийгүй дэлхий нийтийн эрүүл мэндийн байгууллагуудын эрхэм зорилго юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын хүрээнд боловсруулсан тогтвортой хөгжлийн зорилтод хэн, хаана, амьдарч байгаагаас үл хамааран хүн бүр чанартай эрүүл мэндийн үйлчилгээг хэрэгцээтэй үедээ санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байхыг тусгасан.

Монгол улсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах асуудлыг чухалчлан үзэж, олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч, оролцогч талуудыг бүрэн тодорхойлж, асуудлыг цогцоор нь авч үзэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага дээр багаар ажиллах, багийн үйл ажиллагааг дэмжих, нөөцийг нэмэгдүүлэх, засаглалын тогтвортой байдлыг хангах салбар хоорондын уялдааг нэмэгдүүлэх чиглэлд цаашид анхаарах шаардлагатай байгаа юм.

2022 оныг Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, сувилагчдын бие даасан байдлыг хөгжүүлэх, мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

Хоёр. Зорилго:

Олон улсын Сувилагчийн өдрийг угтан сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч санаачлага бие даасан байдлыг идэвхжүүлэх, ёс зүй харьцаа хандлагыг сайжруулахад оршино.

Хоёр. Зохион байгуулагч: ХУЭМТ-ийн Чанарын алба, Сувилахуйн алба, Халдвар хяналтын алба

Гурав. Хамрах хүрээ: ЭМТ-ийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд

Дөрөв . Хугацаа: 2022 оны 04-р сарын 26-наас 05 сарын 10-ны хооронд

Тав. Шалгаруулалт урамшуулал

Аяны хугацаанд хийсэн аяны тайланг 5 сарын 09-10 өдрийн 12⁰⁰ цаг хүртэл хүлээн авна. Ажлын хэсгийн гишүүд шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, онооны дараалалаар байр эзлүүлэн дараах чиглэлээр шалгаруулж урамшуулалыг олгоно.

Тэргүүн байр- 1 гадаад улсад туршлага судлах

Дэд байр- 1 цалингийн 50%

Гутгаар байр-1 цалингийн 30%

Тусгай байр- 1 цалингийн 10% тус тус шагнаж урамшуулна.

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
11/24-р тушаалын гуравдугаар хавсралт

АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Аяны удирдамж, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлуулах	04 сарын 25	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2	Аяны удирдамж төлөвлөгөө шалгуур үзүүлэлтийг тасаг нэгжид танилцуулах	04 сарын 26	Сувилахуйн шуурхай зөвлөгөөн, дотоод группээр
3	Аяны хэрэгжилтийн явцын үнэлгээг шалгуур үзүүлэлтээр 2 удаа дүгнэнэ	Аяны хугацаанд	Ажлын хэсэг
4	Е-Health программын шивэлтэнд хяналт үнэлгээ хийнэ	04 сарын 26-05 сарын 10	Даатгалын эмч А.Бүрнээ
5	Аяны хугацаанд хийсэн ажлын тайланг хүлээн авна	05 сарын 10	Сувилахуйн албаны дарга Б. Халиунгэрэл Чанарын менежер Ц.Оюунчимэг
6	Шалгаруулалтыг ажлын хэсгээс хийж, дүнг гаргана	03 сарын 10	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
7	Шагналыг гардуулах ёслолын үйл ажиллагаа	05 сарын 12	ОУ-ын Сувилагчийн өдрийг тэмдэглэх комисс

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2024. оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
01/04-р тушаалын дөрөвдүгээр хавсралт

ШАЛГУУР ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Үнэлгээний шалгуур үнэлгээ	Дүгнэх оноо
Ерөнхий шалгуур үзүүлэлт- Бүрэн 5, Дутуу 3, Хийгдээгүй бол 0		
1	Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн ур чадвар 95-100 % тай байх	
2	Халдвар хамгаалалын стандарт сэргийлэлтийг мөрдөн ажиллаж байгаа байдал	
3	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, судалгаатай ажилласан байдал	
4	Холбогдох анхан шатны маягт, цахим бүртгэлийн хөтлөлтийн байдал	
5	Сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ санаа, сайн туршлага нэвтрүүлсэн байдал / үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр бол давуу тал болно/	
Тусгай шалгуур үзүүлэлт / оноо тэнцсэн тохиолдолд тусгай шалгуур үзүүлэлт- - Бүрэн 5, Дутуу 3, Хийгдээгүй бол 0/		
6	2022 онд ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх	
7	Ажлын цаг ашиглалт, кабинетийн эмх цэгц, цэвэрлэгээ	